



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 1317

Улаанбаатар хот


**Барилга байгууламж
бүртгэлээс хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дах хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 02/24 дүгээр тогтоол, Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2019 оны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Барилга байгууламжийн дансанд бүртгэлтэй 23 712 000 /хорин гурван сая долоон зуун арван хоёр мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Хан-Уул дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Цагдаагийн түр саатуулах байрлаж байсан хуучин барилгыг нээлттэй дуудлагын худалдаагаар хувьчилсан тул данс бүртгэлээсээ хасч, өмчийн бүртгэлийн мэдээллийн санд холбогдох өөрчлөлт хийхийг Ерөнхий нягтлан бодогч /Н.Уранчимэг/-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн бүртгэлийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийгдсэн эсэхэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /Н.Раднаасэд/-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ